

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн нэгдсэн арга хэмжээг сайтар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.				
1.	<p>- Дүүргийн Засаг даргын 2022 оны А/174 дүгээр захирамжаар “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг”-ийг байгуулсан. Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хороодын хөгжлийн бэрхшээлтэй 562, бүтэн өнчин 120, нийт 682 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлэг гардуулсан. 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 11.00-17.00 цагийн хооронд Тусгаар тогтнолын талбайд хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг “Улаан театр” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын 150 гаруй сурагчдыг хамруулж, нийт 3000 гаруй эцэг эх, хүүхэд багачуудыг арга хэмжээнд хамруулаа.</p> <p>- Мөн хоол үйлдвэрлэл, худалдаа 18, нүүрэн дээр зураг зурах үйлчилгээ 1, киосктой зайрмагийн худалдаа 3, тоглоомын үйлчилгээ 13 нийт 35 худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн шаардлага, стандартыг мөрдөж, хоол хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган худалдаа үйлчилгээгээ явуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч хяналт тавин ажилласан.</p> <p>- Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд “Жүр үр” ХХК-тай хамтран 2022 оны 05 дугаар сарын 31, 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд тус дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Б.Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд “Аз жаргалын хотхон” евент арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд хүүхэд, багачуудыг үнэ төлбөргүй тоглуулж, гэр бүлийн хамт дурсамжтай мөчийг өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.</p> <p>- Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан Хүүхдийн баярын арга хэмжээнд дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо хамтран нийт 7 асарт хоол үйлдвэрлэл 1, худалдаа үйлчилгээ 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

Үүрэг, даалгавар ХОЁР: Иргэд, олон нийтийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах, эцэг, эхчүүд хүүхдүүдээ гэнэтийн осол эндэгдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргэх.

2.	<p>- Дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан эцэг, эхчүүд хүүхдүүдээ гэнэтийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторк зөвлөмжийг бэлтгэн дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэсийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж байна. Хандалтын тоо 1450.</p> <p>- Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан цагдаагийн байгууллагаас “Хүүхэд таныг хамгаалъя” арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, хүүхдийг зам тээврийн болон гэнэтийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр MN25 телевизтэй хамтран ажиллаж, иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг хүргэж, хүүхдийг зохих дүрмийн дагуу тээвэрлэн замын хөдөлгөөнд соёлтой оролцсон жолоочид гарын бэлэг гардуулан өгч ажилласан. Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж 20 цэгт 41 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй авто замын хөдөлгөөнийг хязгаарлан, аюулгүй байдлыг хангуулан ажилласан. Хэв журам сахиулах чиглэлээр 64 алба хаагч, “Сүхбаатарын талбай”, “Тусгаар тогтнолын талбай”, “Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн” болон гудамж талбай, зуслангийн бүсэд иргэд олон нийтийн амгалан байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан.</p> <p>- Дүүргийн 1-20, 24 дүгээр хороодын засаг дарга нарт “Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цахилгааны ил гарсан утас, ухсан нүх, явган хүний замын тэмдэглэгээ, орц, гарц, сургууль, орчмын хурд сааруулагч, тоглоомын талбайн эвдрэл гэмтэлд хяналт тавьж, эзэнгүй муур нохойнд хүүхэд хазуулж бие эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр” 26л-1/3561 дугаартай албан бичиг хүргүүлж хариуг тооцон ажилласан.</p> <p>- Дүүргийн 1-20, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Шингэрүүлсэн хий”, “Сүм, хийд”, “Сэрэмжлүүлье, анхааруулъя”, “Тэнэмэл” зэрэг 4 хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Прокурорын газартай хамтран газ, будаг шингэлэгч, шингэрүүлсэн хий худалдан борлуулдаг 97 аж ахуй нэгж байгууллагад 2022 оны 26л-1/3615 дугаартай зөвлөмж хүргүүлж ажилласан байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
----	--	---	---------------------------------------	-----

Үүрэг, даалгавар ГУРАВ: Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт иргэдийн санал асуулгыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл авах тул хороодыг шаардлагатай мэдээллээр хангаж, иргэдийг идэвхтэй оролцуулах. /Дүүргийн Засаг дарга нар болон нийт байгууллагууд/

3.	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2022.05.31-ний өдрийн 03/2874 тоот албан бичгийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний цахим санал асуулгыг Дүүргийн хэмжээнд идэвхжүүлэн нийт албан хаагчийг бүрэн	=	Үүрэг даалгаврын	50
----	--	---	------------------	----

	хамруулан, хорооны оршин суугч иргэдээс өнөөдрийн байдлаар 27314 саналыг Onhs.mog.gov.mn сайтад оруулсан.		хэрэгжилт хангагдана	
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Амралтын өдрүүдэд хүүхэд багачууд, залуучууд, гэр бүлээр чөлөөт цагаа тав тухтай, өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, соёл урлаг, үзвэр үйлчилгээг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах.				
4.	- Дүүргийн 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох, иргэн, гэр бүл, байгууллага, хамт олныг эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог дэмжих зорилгоор “Эртэч Чингэлтэйчүүд” аяныг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, 7 хоног бүрийн Бямба гаригт явган алхалт хийж, соёл урлагийн үйл ажиллагаагаар үйлчилсэн ба аяны хүрээнд нийт 150 гаруй байгууллагын 6000 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийг хамрагдуулсан. Мөн уран бүтээлийн “Цэгц аравт” холбоо ТББ-тай хамтран “Хүрээ үдэш & City Night” арга хэмжээг дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Б.Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд 2022 оны 05 дугаар сарын 27, 28, 29-ний өдрүүдэд 17:00-21:00 цагийн хооронд зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр соёл урлагийн тоглолт, Яруу найргийн уншлага, Номын худалдаа, Уран бичлэг бичих үйлчилгээ, Хүнсний худалдаа, Пянзны худалдаа, Илбийн үзүүлбэр, Хотын дуунууд, Хотын хөгжим зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 300 гаруй иргэд хамрагдсан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ТАВ: Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ил задгай архидан согтуурч, танхайрч, иргэдийн ая тухтай байх нөхцөл байдлыг алдагдуулж байгаад анхаарч ажиллах. /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Дүүргийн Засаг дарга нар/				
5.	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ил задгай архидан согтуурсан 57 иргэнийг 1,395,000 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцож, иргэдийн ая тухтай байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авто эргүүлийн 10 чиглэлд ажиллаж байгаа 60 алба хаагчдад иргэдээс ирүүлсэн дуудлага мэдээлэлд цаг алдахгүй шуурхай очиж шалган шийдвэрлэх, хариуцсан чиглэл дээр хяналтыг сайжруулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Чингэлтэй дүүргийн 10-19 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг нийтийн зориулалттай орон сууцны эзэмшигчидтэй "Нийтийн байр" тусгай арга хэмжээг хамтран зохион байгуулан “Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд үйл ажиллагаа явуулахдаа аюулгүй, амгалан тайван орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг арилгаж, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн 2 дугаар хэлтсийн төлөөлөл уулзаж, санал хүсэлтийг нь хүлээн авч, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтран ажиллах түншлэлийн гэрээ"-г байгуулсан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

Үүрэг, даалгавар ЗУРГАА: Зөвшөөрөлгүй гарааш, хайс, хашааг буулгаж орц, гарцыг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлж, чөлөөлсөн талбайг тохижуулах ажлуудаа шуурхай зохион байгуулж, иргэд, олон нийтэд нээлттэй тогтмол мэдээлж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Газар зохион байгуулалтын алба, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хотын стандарт хяналтын газар/

	<p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашийн газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу 12 байршлын 168 объект чөлөөлөхөөс 10 байршлын 143 ширхэг объектыг чөлөөлж, 92,950,000 төгрөгийн төсөвтэй газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, талаар авах зарим арга хэмжээний тухай” А/585 дугаар захирамжийн хүрээнд нийт 51,1м2 газрыг чөлөөлөв. Газрын зөрчил арилгах календарьчилсан төлөвлөгөөний дагуу иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>1. Дүүргийн 2 дугаар хороо Их тойруу, Бөмбөгөр худалдааны төвийн зүүн хойно 2 ширхэг төмөр хашаа хайс /37,6 м2/ Жигжиджавын гудамж Бродвэй рестораны ард-1 ширхэг төмөр хаалга</p> <p>2. 4 дүгээр хороо Засгийн газрын 12 дугаар байрны баруун урд “Астра” төвийн 2 ширхэг төмөр хашаа хайс /7,5 м2/ Баруун сэлбийн гудамж Геоэкологийн хүрээлэн-15 ширхэг шон</p> <p>3. 5 дугаар хороо Урт цагааны хойно 1 ширхэг төмөр хашаа хайс /6м2/ Баруун сэлбийн гудамж Хас банкны урд-30 ширхэг шон буулган ажилласан.</p> <p>- Дүүргийн 5 дугаар хороо 24 дүгээр байрны баруун талын газрын зөрчлийг арилган 1100 м2 нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах саналыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Газрын менежмент төлөвлөлтийн хэлтсийн дотоод сүлжээнд судалгаа, танилцуулгыг байршуулсан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<p>Үүрэг, даалгавар Долоо: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ ногоон байгууламжууд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх, моджуулах, тохижилт, хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх ажлуудаа эрчимжүүлж, иргэд, олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэж ажиллах.</p>				
7.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газраас хаврын мод тарих аяныг 2022 оны 05 дугаар сарын 13-15,21,22-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран нийт 34219 мод таригдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Жуулчны гудамж-2500 ширхэг хайлаас • Ж.Самбуугийн гудамж-12500 хайлаас (нөхөн сэргээлт болон шинэ тарилт) • “Хайрхан хөгжлийн төв” УСҮГ - 10363 мод (хайлаас, бургас, нарс, гацуур, улиас, агч, шар хуайс, монос, голт бор, балгана, гүйлс, буйлс,) 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

	<ul style="list-style-type: none"> “Хоймор хайрхан амралт” ОНӨТҮГ - 8856 мод (хайлаас, нарс, гацуур, чацаргана) Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тусгаар тогтнолын талбайд 4000 ширхэг нэг наст цэцгийг 44 м² талбайд тарьсан. <p>Мөн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын ажлын хүрээнд усалгааны 8 тонн бүхий Камаз авто машин, мэргэжлийн 20 цэцэрлэгчин, тусгай багаж хэрэгслийн бэлтгэлийг бүрэн хангаж, өдөр тутмын усалгаа, арчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.</p>			
Үүрэг, даалгавар НАЙМ: Авто замын засвар болон инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлийн ажлууд хийгдэж байгаатай холбогдуулан авто зам хаах, хэрэглээний халуун, хүйтэн ус хязгаарлах тухай мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэж ажиллах.				
8.	Энхтайвны өргөн чөлөөнөөс хойш Их тойруу хүртэлх авто замын засвар шинэчлэлт, Их дэлгүүрийн зүүн урд уулзвараас Самбуугийн гудамж хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажлын мэдээллийг дүүргийн дүүргийн албан ёсны цахим хуудас “Чингэлтэй дүүрэг” пэйж хуудас www.chingeltei.gov.mn сайт, 2, 3, 4 дүгээр хороодын албан ёсны цахим хуудсанд байрлуулж иргэд, олон нийтэд мэдээлэлийг хүргэсэн.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ЕС: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэж байгаа болон хийгдэх гэж байгаа ажлуудын талаарх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах./Нийт байгууллагууд/				
9.	Чингэлтэй дүүргийн 10, 14, 15, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй авто замын засвар шинэчлэлтийн ажлын мэдээллийг дүүргийн албан ёсны цахим хуудас болох “Чингэлтэй дүүрэг” пэйж хуудас www.chingeltei.gov.mn сайтад байршуулж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Мөн дүүргийн 19 дүгээр хороо дээд Салхитын “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн” байрлах “Дээд салхит Соёл үйлчилгээ”-ний гурван давхар барилгын ажлын үйл явц, дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгуулсан 1000 хүний суудалтай, гурван блок бүхий дөрвөн давхар Спорт цогцолбор ашиглалтад оруулсан, талаар, "Газрын зөрчил арилгах тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн хүрээнд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эдэлбэр газарт зөвшөөрөлгүй барьсан гражийг чөлөөлөх ажлын талаар, Нийслэлийн Замын хөгжлийн газар авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын хүрээнд дүүргийн Ж.Самбуугийн гудамжны авто зам, Баруун Сэлбийн гудамжны авто замын засварын шинэчлэлтийн ажлыг мэдээлж “Чингэлтэй дүүрэг” пэйж хуудсаар хүргэсэн байна. Мөн Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороонд Ерөнхий боловсролын 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн шав тавих ёслолын үйл ажиллагааг “Чингэлтэй дүүрэг” пэйж хуудас www.chingeltei.gov.mn сайтад байршуулан	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

	олон нийтэд мэдээлж ажилласан. Дээрх мэдээлэхийг 15,062 хүн үзэж, 236 удаа таалагдаж, авч, 49 эерэг сэтгэгдэл, 245 хуваалцсан байна.			
Үүрэг, даалгавар АРАВ: Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээг хийх, үерийн далан сувгийг зориулалтын бусаар өөрчилсөн зөрчлийг арилгуулах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлуудаа тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.				
10.	Чингэлтэйн өргөн чөлөөний авто замуудын борооны ус зайлуулах шугамын хог, лагийг цэвэрлэх ажлыг Геодези, усны барилга байгууламжийн газраас хийж гүйцэтгэлээ. Мөн Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК-ний харьяа иргэдийн бүлгийн нийт 30 гишүүний бүрэлдэхүүнтэй түүвэр цэвэрлэгээг дүүргийн гэр хорооллын үерийн далан суваг, гуу жалга дагуух хог хаягдлыг хуваарийн дагуу 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Цэвэрлэгээний явцад нийт 21000 м2 талбайн 48,0 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

У.МАГНАЙ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ